



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 111

Мандалговь

**Н.Эрдэнэ-Очирыг шагналд  
нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнах журмын 3 дугаар бүлгийн 3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Төрийн албанд олон жил идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажиллаж, орон нутагт төр засгийн бодлого шийдвэр, төрийн албаны шинэтгэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, үр дүн гаргаж байгаа аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Норовжавын Эрдэнэ-Очирыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнуулахаар Төрийн албаны зөвлөлд уламжилсугай.

Хоёр. Ш.Төрбатын шагналын материалыг журмын дагуу бүрдүүлж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Хуланд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ

